


БАТЛАВ.



“Байгууллагын сэтгүүлийн загвар шинэчлэх, эх бэлтгэх” багц-1
нийлүүлэх гэрээ

Дугаар № ХХЗХ/202112029

Улаанбаатар хот

Нэг талаас Харилцаа холбооны зохицуулах хороо (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас Бизнес медиа ХХК (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2021 оны 06 сарын 25-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь “Байгууллагын сэтгүүлийн загвар шинэчлэх, эх бэлтгэх” багц-1 ХХЗХ/202112029-г (цаашид “бараа” гэх) **9,240,000 (ёсөн сая хоёр зуун, дөчин мянга)** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг 100 хувь өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан нэр төрлийн барааг 2021 оны 06 дугаар сарын 25 -наас 2021 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Үнийн санал болон үнийн хуваарь;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ЗУХАГ-ын дарга З.Эрдэнэчулуун



ХАХХ-ийн дарга Б.Мягмарнаран



ЗУХАГ-ын мэргэжилтэн
Д.Наранболонго




ТАМГА

Метро бизнес төв А корпус 5 давхар
Сүхбаатарын гудамж-13 Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар 14201-0033 Утас:11-304258
Факс:327720

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:


Бизнес Медиа ХХК-ийн захирал

Д.Бэхбаяр



Маркетингийн менежер

Х.Оюударь





ТАМГА

Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо,
Энхтайваны өргөн чөлөө, Экспресс тауэр, 11
давхар, 6 тоот
Цахим шуудангийн хаяг:
info@mongoliaeconomy.mn
Утас/факсын дугаар: 70115476
Харилцагч банкны нэр, дансны дугаар:
Худалдаа хөгжлийн банк:
УБД: 9011777041
РД:6373127

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа 1 жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй -гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1) 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5) 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7) 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн **30** хувийг барааны контент бэлэн болж хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн барааг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор төлнө. Үлдсэн 70 хувийг эх бэлтгэл хийгдэж захиалагч хүлээн актаар хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт багтаан олгоно.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹ 9.1. Алданги оногдуулах хувь: **Нэг долоо хоногт 0,3 хувь**
- Алдангийн нийт дүн: **10 хувь**

¹ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

Барааны тодорхойлолт, нийлүүлэлтийн хуваарь

Монгол Улсад мэдээлэл харилцаа холбооны салбар үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойд зориулсан сэтгүүлийн тусгай дугаар. Тус салбарын түүхэн хөгжлийн өнгөрсөн, өнөө ба ирээдүй, хөгжлийн цаашдын төлөвийг хэрхэн тодорхойлж буй болоод дурсамжийн хүрээнд нийтлэл ярилцлага бүхий цогц дугаар байна.

Сэдэв: Хөгжлийн 100 жил
Хэл: Монгол
Хугацаа: 2021.07.05
Хуудасны тоо: 120

Д/д	Булан, нийтлэл	Агуулга
1	Мэндчилгээ	Ерөнхий сайд, ХХЗХ-ны дарга Г.Чинзориг, ХХМТГ-ын дарга Б.Болор-Эрдэнэ
2	Онцлох сэдэв	Салбарын 100 жилийн хөгжлийн түүхийг харуулсан нийтлэл Инфографикаар үзүүлэх
3	Хөрөг нийтлэл	10 хүн ХХЗХ-ны дарга гэх мэт
4	Инфомэдээлэл	Салбарын онцлох тоон мэдээллээс. Улсын эдийн засгийн хөгжилд гүйцэтгэсэн үүрэг ба тоо статистик сүүлийн 30 жил ба, сонирхолтой тоонууд
5	Түүх: Технологийн хөгжлийн үе	Салбарын анхлан байгуулагдсан 1921 оны түүхэн үйл явдлаас, технологийн хөгжил
6	Технологийн хөгжлийн үе-2	Энэ үеийн салбарын, технологийн хөгжлийн онцлог
7	Зах зээлийн эдийн засгийн харилцааны үе Технологи	Зах зээлийн системийн 30 жилийн салбарын хөгжлийн онцлог гэх мэт
8	Дурсамж, сэтгэгдлүүд:	Салбарын удирдлагууд, мэргэжилтэн, ажилтнууд, төрийн түшээд гэх мэт Маш товчхон, номоос авна
9	Анхдагч:	Энэ буланд салбарын анхдагч болсон үйл явдлуудын тухай бичнэ. Анхны хууль, анхны удирдлага, анхны компани, анхны харилцагчид гэх мэт
10	ГХО ба хөгжил нийтлэл	Салбарын ГХО-ын тухай, салбарын хөгжилд гүйцэтгэсэн үүрэг, томоохон хөрөнгө оруулагчдын талаар
11	Компаниудын хөгжил ба тоо	Салбарын компаниудын талаар, ямар үйл ажиллагаа явуулдаг, хичнээн компани байгаа, ангилал, засаглалын байдал гэх мэт инфографикаар тайлбартай өгөх
12	Салбарын онцлог 100 үйл явдал	Гол түүхэн ач холбогдол бүхий 100 үйл явдлыг бичих

13	Зохицуулалт	Салбарын зохицуулалт түүхэн хөгжлийн үед хэрхэн өөрчлөгдөж ирсэн гэх мэт
14	Гадаад хамтын ажиллагаа	Гадаад хамтын ажиллагааны онцлог үйл явдал, бодлого гэх мэт
15	Дэлхийн чиг хандлага нийтлэл	Салбарын дэлхийн хөгжлийн чиг хандлага, сүүлийн үеийн технологи гэх мэт
16	Шилдэг технологийн компани нийтлэл	Дэлхийн шилдэг технологи, технологийн компаниудын тухай
17	ХХЗохицуулалт ба 5 G	Илтгэлээс авах
18	ХХЗГ 25 жил нийтлэл	Номоос гаргах
19	Сэтгүүлийн тухай нийтлэл	Салбарын сэтгүүл, тоймлох
20	Фото түүх өгүүлнэ	Түүхэн зургаас 1-2 нүүр Номоос авах
21	Эх бэлтгэлийг	Чанарын өндөр түвшинд бэлтгэх, In файлаар хүлээлгэн өгөх